

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН МЭДЭЭ

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар:

Хөвсгөл аймагт 2023 оны 05 дугаар сард төрийн албаны ерөнхий шалтгал 8 ээлжээр хоёр өдөр амжилттай зохион байгуулагдлаа. Ерөнхий шалгалтад 164 иргэн бүртгүүлж, 124 иргэн шалгалтад орж, 60 иргэн тэнцсэн ба нийт шалгалтад орсон иргэдийн 47.2 хувь нь төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртэгдэх боломжтой болсон.

Цахим хөгжил, харилцаа холбооны яамны сайд, Аймгийн засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Хөвсгөл аймагт Төрийн цахим үйлчилгээний хэлтэс байгуулагдаж, аймгийн Засаг даргын Тамгын газрын “А” байрны 1 давхарт төрийн цахим үйлчилгээний “Хурдан” төвийг байгууллаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газраас “Хурдан” төвийн тохижилт үйлчилгээ, нээлтийн зардалд зориулж 23,426,000 төгрөгийг Засаг даргын дэргэдэх удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцэн засаг даргын нөөц сангаас шийдвэрлэсэн.

“Хурдан” төв операторын горимоор 39 төрийн байгууллагын 440 үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд хүргэн ажиллаж байна. 2023 оны 05 дугаар сарын 28-ны байдлаар 129 иргэн 400 гаруй төрийн үйлчилгээг уг төвөөс авсан байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газраас цахим шилжилтийн хуулиудын хэрэгжилтийг хангах, операторуудын цахим ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор Төрийн Цахим үйлчилгээний зохицуулалтын газарт сургалт авах хүсэлт өгсний дагуу 2023 оны 5 дугаар сарын 10-ны өдөр 23 сум, 1 тосгоны Операторын системээр үйлчилгээ үзүүлж буй албан хаагчид болон “Хурдан төв”-ийн операторуудыг чадавхжуулах сургалтыг хамтран танхимаар зохион байгуулав.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс, аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Хуульчдын холбоотой хамтран төрийн болон хувийн хэвшлийн нийт 38 байгууллагын оролцоотойгоор “Бидний үйл ажиллагаа –Таны нүдээр” уриатай Нээлттэй хаалга”-ны өдөрлөгийг 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдөр зохион байгууллаа.

Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын үйл ажиллагааг иргэдэд сурталчлах, таниулах, зарим төрлийн үйлчилгээг нэг дороос авах нөхцөлийг бүрдүүллээ. Өдөрлөгийн үеэр байгууллагууд иргэдээс гарсан санал гомдлыг газар дээр нь шийдэх боломжтой асуудлыг нь шийдэж, харьяа газруудад уламжлах саналуудыг эрэмбэлэн хүргүүлж, Мөн иргэдэд хууль зүйн зөвлөгөө өгөх ажил тус тус зохион байгууллаа.

Хоёр. Хууль, эрх зүйн хүрээнд:

ХҮНСНИЙ ЧАНАР СТАНДАРТ, ЭРҮҮЛ АХУЙН ХЯНАЛТААР:

Хүнсний чанар, стандарт, эрүүл ахуйн их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн нийт 108 объект төлөвлөснөөс эхний хагас жилд 41 объектод төлөвлөгөөт хяналт шалгалтыг зохион байгууллаа. Аймгийн Нэгдсэн эмнэлэг, хувийн хэвшлийн ортой эмнэлэг, шүдний эмнэлэг,

сумын Эрүүл мэндийн төв, сургууль, цэцэрлэг, хүнсний чиглэлийн 15 объектод хамтарсан хяналт шалгалт хийж холбогдох газруудад албан шаардлага, нэгдсэн танилцуулгыг хүргүүлэн ажиллалаа. Нийт хяналт шалгалтад хамрагдсан объектуудын эрсдэл үүсэх магадлал дунджаар 49.77%, хууль сахин мөрдөлтийн хувь дунджаар 50.53 хувьтай байна. “Нийтийг хамарсан баяр ёслол, цаг үеийн шаардлагаар зохион байгуулж буй арга хэмжээнд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” 08-00/01 удирдамжийн хүрээнд

Мөрөн сумын ЗДТГ, ХХААГ, МЭГ-тай хамтран хүнсний 5 үйлдвэр, 116 хүнсний худалдаа, хоол үйлдвэрлэлийн 13 ААНБ-д урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийлээ. Шалгалтын явцад хугацаа дууссан, чанар аюулгүй байдал алдагдсан бараа бүтээгдэхүүн худалдаалж байсан 10 объектын 39 нэр төрлийн 346ш, 15кг, 1377500төгрөгийн бараа бүтээгдэхүүнийг битүүмжилсэн байна. Улсын байцаагчийн 2 зөвлөмж, 2 акт гарган холбогдох газруудад хүргүүлэн ажиллаа. Нийт 339 зөрчил илэрч 102 зөрчил буюу 30 хувийг газар дээр нь арилгах арга хэмжээ авлаа.

БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

"Хүн бүр байгаль хамгаалагч" аяны хүрээнд Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас баталсан төлөвлөгөөт хяналт шалгалтын удирдамж, Мөрөн сумын Засаг дарга Байгаль орчин аялал жуулчлалын газрын даргын баталсан удирдамжийн хүрээнд Мөрөн суманд үйл ажиллагаа явуулж буй загас, загас бүтээгдэхүүн үйлдвэрлэж худалдан борлуулдаг иргэн, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж зөвлөмж чиглэл өгч ажиллалаа. Бүрэнтогтох сумын Дулааны төвийн хаягдал утаанд хэмжилт хийв. Бүрэнтогтох сумын Засаг даргатай уулзаж, Туяа багийн нутагт хамрагдаж буй Дэлгэрмөрөн голын сав газарт эвдэрсэн газруудад нөхөн сэргээлт хийгдсэн ажлын талаар болон цаашид хийгдэх нөхөн сэргээлтийн ажлыг нөхөн сэргээлт хийх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээр хийлгэх, нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийж байгаад хяналт тавих, гэрээ хийж байгаа бол гэрээний биелэлтийг гаргаж, хүлээн авах акт үйлдэх талаар санал солилцлоо.

Байгаль орчин аялал жуулчлалын яамны ажлын хэсгийн хамт Цэцэрлэг сумын Могойн голын уурхайн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, экспортын нүүрс тээвэрлэлтийг түр зогсоох актыг гарган, шалгалтаар илэрсэн дутагдлыг арилгуулах албан шаардлага хүргүүлэн биелэлтийг хангуулахаар хяналт тавин ажиллаж байна.

Цэцэрлэг сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа Хургатай хайрхан ХХК-ний үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхэд тус аж ахуйн нэгжийн уурхай дээр байвал зохих баримт бичиг бүрдүүлбэр дутуу байсан тул холбогдох баримт бичгийг шалгах ажлыг нөхөн хийж гүйцэтгэн, илэрсэн дутагдлыг арилгуулах албан шаардлага хүргүүлээ.

ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, СУРГАЛТ СУРТАЛЧИЛГАА:

Онцгой байдлын ерөнхий газраас явуулж байгаа “Бэлэн бай” аянд нэгдэж 3 QR код бүхий самбарыг зах худалдаа үйлчилгээ, иргэд олноор үйлчлүүлдэг газруудын байршилд байрлуулж, томоохон 20 худалдаа үйлчилгээний төв, банк, том сүлжээ дэлгүүрийн хаалга, мэдээллийн буланд байрлуулж 270 ширхэг “бэлэн бай” брошурыг тарааж ажилласан.

Мөн ангийн алба хаагчид цахим орчинд “Бэлэн бай” аян мэдээллийг шэйр, хийж лайк дарж иргэдийн хандалтыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ бусдад мэдээ, мэдээллийг түгээж цахим

орчинд түгээсэн мэдээлсэн илтгэх хуудсыг өдөр бүрийн 15 цагт нэгтгэж хариуцсан мэргэжилтэнд хүргүүлэн ажиллаж байна.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан “Ногоон бүсийн айл өрх, амралтын газар, жуулчны баазын барилга байгууламжид гамшгаас хамгаалах, галын аюулаас урьдчилан сэргийлэх болон гүйцэтгэлийн хяналт шалгалт зохион байгуулах удирдамж”-ийн дагуу Мөрөн, Тариалан, Галт, Цагаан-Уул, Хатгал тосгонд үйл ажиллагаа явуулж буй амралтын газар, жуулчны баазын барилга байгууламжид хяналт шалгалтыг хийж гүйцэтгэж ажиллаа.

Төлөвлөгөөт хяналт шалгалтаар 23 ногоон бүсийн айл өрх, 11 амралтын газар, жуулчны баазын барилга байгууламжийг хамруулж нийт 126 зөрчил дутагдал илэрснээс 47 зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулж бусад зөрчил дутагдлыг арилгуулахаар гал түймрийн улсын хяналтын байцаагчийн эрх зүйн бичиг баримтыг холбогдох албан тушаалтанд хүргүүлж ажиллаа.

Хөвсгөл аймгийн хэмжээнд 2023 оны 05 дугаар сард объектын гал түймэр 4 суманд нийт 7 удаа гарч өвөл, зуны сууц- 3, 5 ханатай монгол гэр- 3, малын хашаа- 1.

Үүнд:

Дээрх гал түймрийн улмаас 107,789,058 төгрөгийн хохирол учирч, 256,320,000 төгрөгийн өмч хөрөнгийг ард иргэд, алба хаагчдын идэвхтэй үйл ажиллагааны үр дүнд авран хамгаалсан байна. Бэлэн байдлыг хангах хүрээнд Онцгой байдлын ерөнхий газрын Мэдээллийн технологийн хэлтэст хэт богино долгионы радио станцыг хүргүүлж 1 станцад суваг суулгуулсан. Гал түймэр унтраах, аврах ангиуд дээр ашиглагдаж байгаа дугааруудын бэлэн байдлыг хангуулан ажиллаж байна. ОБГ-ын хэмжээнд 3 зөөврийн компьютер, 2 суурин компьютерт SSD картыг суулгасан.

ХҮҮХДИЙН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:

Хүүхдийг гэмт хэрэг, зөрчил, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Хүүхэд хамгаалал” ерөнхий арга хэмжээ, “Хамтдаа хамгаалъя”, “Нэг анги нэг алба хаагч”, хэсэгчилсэн арга хэмжээг тус тус зохион байгуулан, хэрэгжилтийг ханган ажиллаа.

Тухайлбал:Титэм ерөнхий боловсролын сургуультай хамтран 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 10-ны өдрийн хугацаанд “Нэг анги-Нэг алба хаагч” арга хэмжээг хамтран зохион байгуулж, 45 анги бүрд алба хаагч нарыг хуваарилан сурагчдад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулж ажиллаа. Арга хэмжээний хүрээнд тус сургуулийн 52 багшид “Хүүхэд хамгаалалд анхаарах асуудал” үндсэн сэдвийн хүрээнд сургалт мэдээлэл хийсэн.

Мөрөн сумын ЗДТГ-тай хамтран тус сумын 2 дугаар багийн хэсгийн ахлагч иргэдэд “Хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх”, “Эрсдэлт нөхцөл байгаа хүүхдийг илрүүлэх, хамтран ажиллах” сэдвийн хүрээнд мэдээлэл хийж, хамтран ажиллаа. Сургалтад 21 хэсгийн ахлагч хамрагдсан.

Охидыг бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Дэлгэрмөрөн цогцолбор сургууль, Эрүүл мэндийн газартай хамтран тус сургуулийн охидын зөвлөгөөнийг хамтран зохион байгуулж, дунд, ахлах ангийн 126 охидод “Бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, өөрийгөө хамгаалах, мэдээлэх”, “Нөхөн үржихүйн эрүүл мэнд” зэрэг сэдвийн хүрээнд мэдээлэл хийсэн. Мөн Сод-Эрдэм, Авъяас, Дэлгэрмөрөн, Ирээдүй, Политехникийн коллежийн нийт 8 ангид сургалт орсон. Сургалтад 240 сурагч хамрагдсан.

Төгсөлтийн баяртай холбоотойгоор тус Цагдаагийн газрын 161 дугаар мэдэгдлийг ерөнхий боловсролын сургуулиудад урьдчилан хүргэж, баярын үйл ажиллагааны үеэр сургуулийн захирлуудтай уулзаж, заавар зөвлөгөө өгч ажилласан. Эргүүлийн үүрэг гүйцэтгэх хугацаанд аймгийн төвийн болон сумын согтууруулах ундаагаар үйлчилдэг баар, караоке, диско клубт давхардсан тоогоор 146 удаа, архи согтууруул ундаа худалдан борлуулах тусгай зөвшөөрөлтэй хүнсний дэлгүүрүүдэд давхардсан тоогоор 813 удаа, Зочид буудал, дэн буудлуудын үйл ажиллагааг давхардсан тоогоор 76 удаа шалгаж зааварчилгаа зөвлөгөө өгч ажилласан.

Тус хяналт шалгалтын үеэр гудамж талбай, олон нийтийн газар шөнийн цагаар согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж зориулалтын бус газар архидан согтуурсан 25 иргэнийг 250,000 төгрөгөөр торгуулийн арга хэмжээ авч ажилласан. Төгсөх ангийн сурагчдад гэмт хэрэг зөрчилд холбогдохгүй байх, архи, тамхины хор уршиг болон хүүхдээс үйлдэгдэг тодорхой төрлийн гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар аймгийн төвийн 9 сургууль, сумын 17 сургуулиудад сургалт мэдээлэл хийж ажилласан.

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:

Аймгийн хэмжээнд 2023 оны эхний 05 сарын байдлаар гэр бүлийн хүчирхийллийн 25 гэмт хэрэг бүртгэгдсэн нь урд оны мөн үетэй харьцуулбал 1.4 дахин буурсан байна. Гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй 84 зөрчил бүртгэгдсэнээс гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн 60 иргэнийг шүүхээр 7-30 хоног баривчлуулж, 210.0 төгрөгийн торгуулийн арга хэмжээ ноогдуулсан байна. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсээс зохион байгуулж буй “Бүртгэл” ерөнхий арга хэмжээний хүрээнд гэр бүлийн радио 104.5-ын “Өглөөний жиргээ” буланд 2 удаа оролцож, иргэд олон нийтэд мэдээлэл хүргэсэн.

“Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга зүй” сэдэвт Хангайн бүсийн цагдаагийн алба хаагчдын сургалтыг Мөрөн суманд зохион байгуулах бэлтгэл ажлыг ханган, 4 аймгийн 30 алба хаагч, 2 сургагч багшийг хүлээн авч сургалтыг амжилттай зохион байгуулсан.

Цагдаагийн газарт энэ оны эхний 5 сард бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн тоон мэдээ болон энэ төрлийн дуудлага, мэдээлэл хүлээн авах, шалган шийдвэрлэх ажиллагааны явц байдалд дүн шинжилгээ хийн Цагдаагийн газрын даргад танилцуулан, 06 дугаартай Цагдаагийн газрын даргын албан үүрэг, ажлын чиглэлийг Мөрдөн байцаах тасаг, Зөрчлийн хэрэг бүртгэх тасаг, Шуурхай удирдлагын тасаг, Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга нарт тус тус өгсөн.

Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд даргын 2023 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 2/162 дугаартай албан бичгээр ирүүлсэн үүрэг ажлын чиглэлийн дагуу мод тарих, түүнийг арчлан ургуулахын ач холбогдолыг олон нийтэд таниулах, соён гэгээрүүлэх, мэдээлэл, сурталчилгааны ажил зохион байгуулах чиглэлээр “Хүн бүр байгаль хамгаалагч-Тэрбум мод-Байгалиа хамгаалъя” нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд салбар төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж ажилласан.

Цагдаагийн ерөнхий газрын Экологийн цагдаагийн албанаас бэлтгэсэн 196 видео, постер мэдээллийг Хөвсгөл аймгийн Цагдаагийн газрын цахим хуудаст байршуулан 16882 хүний хандалт авч, 36768 удаа хуваалцсан. Тус Цагдаагийн газраас “Хүн бүр байгаль хамгаалагч-Тэрбум мод-Байгалиа бүтээе” аяны хүрээнд 11 мэдээ, мэдээлэл оруулж 406 удаа хуваалцаж иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэлээ.

Гурав. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд:

Төрийн сангийн төлбөр тооцооны программаар 2023 оны 04 дүгээр сард 81 Төсөвт байгууллагын үндсэн болон нэмэлт санхүүжилтийн данснаас **11.8** тэрбум төгрөгний **2597** ширхэг гүйлгээ шивэгдсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн 2023 оны 05-р сарын мэдээгээр Орон нутгийн орлого, санхүүжилт 17,892.4 сая төгрөгний төлөвлөгөөтэйгээс 19,574.6 сая төгрөг буюу 109.4 % хувийн гүйцэтгэлтэй байна.

Төсвийн гүйцэтгэл 2023 оны 04-р сарын мэдээгээр Орон нутгийн байгууллагуудын төсвийн зарлагын гүйцэтгэл батлагдсан 24,580.8 сая төгрөг байгаа бөгөөд үүнээс 1,874.6 сая төгрөг нь татварын бус орлого буюу өөрийн орлогоос, 22,346.3 сая төгрөг нь төсвөөс санхүүжих, 7,324.1 сая төгрөг нь улсын төсөв болон орон нутгийн төсвөөс, 2,811.3 сая төгрөг орон нутгийн хөгжлийн сангаас тус тус санхүүжигдсэн байна. Төсвийн гүйцэтгэлийн мэдээнд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр 24,580.8 сая төгрөг, зарлагын гүйцэтгэл 13,905.1 мянган төгрөг буюу 56.6 % хувьтай байна.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр Төсвийн нийт авлага **5,227.1** сая төгрөг өмнөх сараас **174.9** сая төгрөгөөр өссөн.

Нийт өглөг **1,334.4** сая төгрөг өмнөх сараас **711.4** сая төгрөгөөр өссөн.

2023 оны 05 сарын байдлаар нийгмийн даатгалын санд шимтгэлийн орлого 3888.9 сая төгрөг, сайн дурын даатгуулагчаас 1273.4 сая төгрөгийн орлого орж орлогын төлөвлөгөө 100.1%-тай байна.

Төлөвлөгөөг сан тус бүрээр нь харуулбал:

/Сая.төг/

Төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
Тэтгэвэр	2800.6	3275	116.9
Тэтгэмж	283.9	311	109.5
ҮОМШӨ	223.4	171.6	76.8
ЭМД	0,0	0,0	0,0
ажилгүйдэл	52.5	52.1	99.2
дүн	3360.4	3809.7	100.6

Тэтгэврийн даатгалын сангаас 21620 тэтгэвэр авагчид 10909.2 сая төгрөгийн 4 төрлийн тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын сангаас 3 төрлийн тэтгэмж 355 даатгуулагчдад 378.8 сая төгрөгийн тэтгэмжийн зардал, үйлдвэрлэлийн ослын сангаас 66 даатгуулагчдад 36.7 сая төгрөгийн тэтгэвэр тэтгэмж, ажилгүйдлийн даатгалын сангаас 168 даатгуулагчид 86.2 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж олгосон байна.

Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 334.5 сая төгрөг байна.

Аймгийн Санхүүгийн хяналт дотоод аудитын алба 2023 оны 05 дүгээр сард Сангийн сайдын 2023 оны 04 дугаар сарын 23-ны өдрийн СХШХ/02 дугаар удирдамжаар батлагдсан “Нийгмийн даатгалын ерөнхий газар болон түүний харъяа газар, хэлтсийн санхүү, үйл ажиллагаа, сангуудад хийх нэгдсэн хяналт шалгалтын удирдамж”-ийн дагуу аймгийн Нийгмийн даатгалын хэлтэст санхүүгийн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

Бага боловсролын хөгжмийн хичээлийн сургалтын хөтөлбөрийн агуулга, зорилготой уялдуулан сурагчийн бүтээлч суралцахуйг дэмжих зорилгоор "Хөгжмийн үзүүлбэр-2023" үйл ажиллагаа Сод-Эрдэм сургуулийн урлаг танхимд зохион байгуулагдаж төвийн 7 сургуулийн 11 бүлгийн 350 сурагч оролцов.

“Оюунлаг Хөвсгөлчүүд” хөтөлбөрийн хүрээнд “Хүүхэд бүрт тэгш боломж-ЭЕШ 2023” сорилгыг 2 дахь жилдээ амжилттай зохион байгуулж, шилдгүүдээ тодрууллаа. Хөвсгөл аймгийн 23 сум, 1 тосгоны ерөнхий боловсролын 32 сургуулийн 12 дугаар ангийн 1491 сурагчаас шалгарсан, шилдэг 105 сурагч 2 дугаар шатанд өрсөлдөж, шилдэг 7 сурагчийг тодруулж, батламжиллаа.

Боловсролын ерөнхий газар, Боловсролын үнэлгээний төв, аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар, Ирээдүй сургууль хамтран Хөвсгөл аймгийн Түнэл сумын ерөнхий боловсролын сургууль дээр нөхцөл байдлын шинжилгээ, сургуулийн хэрэгцээнд үндэслэн хөтөлбөрийн хэрэгжилт, үнэлгээ, хүүхэд хамгаалал, сайн туршлага, бүтээлч санаачилгыг илрүүлэн түгээн дэлгэрүүлэх зорилтын хүрээнд зөвлөн тусалж, хамтран ажиллалаа.

“Шинэ эгэл арга зүйгээр хичээлийн хоцрогдлыг арилгах нь” төслийн хүрээнд Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын сургуулийн физикийн багш нар, математик, физикийн хичээлээр элсэлтийн ерөнхий шалгалт өгөх 10-12-р ангийн сурагчдад зориулан цахим хосолсон сургалтыг Мөрөн сумын Титэм сургууль, Рашаант, Тосонцэнгэл сумын сургууль дээр амжилттай зохион байгуулав.

“Байгууллагын менежментийг сайжруулах жил” болгосонтой холбогдуулан цэцэрлэгийн менежментийг сайжруулах өөрийн үнэлгээ, төлөвлөлт хийх арга зүйн сургалт, зөвлөн туслах үйл ажиллагаа Мөрөн сумын 6 дугаар цэцэрлэгт явагдав.

1-9 дүгээр ангийн хөгжмийн хичээлийн 500 төстийн сантай "Дасгал ажлын дэвтэр"-тэй болов. "Мэргэжлийн бүлэг- хамтын хөгжил" арга хэмжээний хүрээнд "Судалъя- хөгжье" бүтээлч даалгаврыг гүйцэтгэж 19 сургуулийн нийт 27 багш хамрагдаж 500 төстийн сантай "Дасгал ажлын дэвтэр" гаргаж ашиглалтад оруулав.

"Sharing is caring" ментор багш нарын сургалтыг "Боловсрол танхим"-д зохион байгуулав. Мөрөн сумын 8 сургуулийн 27 багш танхимаар, сумдын багш нар /64/ цахимаар хамрагдав. Pearson хөтөлбөр хэрэгжиж байгаа сургуулиудын 5-8 дугаар ангиудын цахим шалгалтуудад Pearson English Teachers-Mongolia багаас өгсөн зааварчилгаа зөвлөмжийн дагуу арга зүйн зөвлөмж өгч ажиллав.

"Eduten" хөтөлбөрийн эцсийн үнэлгээний судалгаа хийх ажлыг Мөрөн Гурван Эрдэнэ сургууль дээр хариуцан зохион байгуулав. Энэхүү судалгаанд тус сургуулийн 46,г ангиудын нийт 72 сурагч хамрагдсан ба материалыг Боловсролын үнэлгээний төвд хүлээлгэн өгөв .

2022-2023 оны хичээлийн жилийн төгсөгчдийн Суурь боловсролын 2636ш гэрчилгээ, бүрэн дунд боловсролын 1540 ш үнэмлэхийг хүлээн авч, сургуулиудын төгсөгчдийн тоогоор тулгалт хийн тараалт хийв.

“Ирээдүйн эзэд- 2023” сургалт зөвлөгөөнийг Мөрөн сумын ерөнхий боловсролын сургууль, Политехникийн коллежийн төгсөх ангийн 350 гаруй сурагчдад оюутныдунд зохион

байгуулж хөдөлмөр эрхлэлт, тэтгэлэгт хөтөлбөрүүд, оюутан болоод хэрхэн амжилттай суралцах вэ, гэх мэт мэдээллийг өглөө.

Дүрслэх урлаг, дизайн технологийн хичээлээр сурагчдын хийсэн уран бүтээлийг таниулан сурталчлах Дизайн технологи, дүрслэх урлагийн хичээлийн 6 онцлог, ач холбогдолыг олон нийтэд сурталчлан түгээх. Сургалтын явцад бүтээлч чиг хандлагыг төлөвшүүлэх үйл явцыг тогтмолжуулан ахиц гаргах зорилгоор Хөвсгөл аймгийн нийт 110-н дизайн технологи, дүрслэх урлагийн багш нар сурагчидтайгаа хамтран үзэсгэлэн гаргав.

" Оюун түлхүүр" дотуур байрын сурагчдын дунд зохион байгуулан наадмыг дүгнэн ажиллав.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Сэхээн амьдруулах, мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээний их эмч Хаянхярваагийн Цэнд-Аюушийн нэрэмжит “Шинэ санаа- Шинэ мэдлэг 2023” сэдэвт Эрдэм шинжилгээний бага хурлыг 9 дэх удаагаа Хөвсгөл аймгийн Эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа эмч, мэргэжилтэн, сувилагч, тусгай мэргэжилтнүүдийн дунд амжилттай зохион байгууллаа.

Уг эрдэм шинжилгээний хуралд 4 чиглэлээр нийт 27 илтгэл хэлэлцүүлэгдэж шилдэг илтгэгч нараа тодруулав.

Жайка олон улсын байгууллага нь анхан ба хоёр дахь шатлалын эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг дээшлүүлэх зорилгоор эмнэлгийн гаднах болон эмнэлэг доторх амилуулах лавшруулсан тусламжийн мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх нь зүйтэй гэж үзсэн ба уг зорилгын хүрээнд Монгол Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатарын ажлын алба, аймгийн Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн газар, Улсын хоёр дугаар Төв эмнэлгийн яаралтай тусламжийн тасгийн эрхлэгч, “Ашид буян” ХХК, Мед импорт Монгол, Монос-Хөвсгөл хамтран “Эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх ур чадварын тэмцээн”-ийг зохион байгууллаа.

Энэхүү тэмцээнд Эрүүл мэндийн газар, Аймгийн нэгдсэн эмнэлэг, сум, өрх, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын шилдэг 15 багийн 90 гаруй эмч, сувилагч тусгай мэргэжилтнүүд мэдлэг ур чадвараа сорилоо.

Төр, хувийн хэвшлийн байгууллагуудын хамтарсан "БИДНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ТАНЫ НҮДЭЭР" нээлттэй өдөрлөгт Эрүүл мэндийн газар, Гурвангал, Дэлгэрмөрөн, Энэрэл, Энх-Үйлс өрхийн эрүүл мэндийн төвүүд оролцож иргэдэд зөвлөгөө мэдээлэл түгээж, Танита аппарат ашиглан биеийн жингийн индекс тодорхойлж ажиллаа. Мөн бүх нийтээр хийж хэвших ТҮМЭН дасгалаа хийж таниулав.

Эрүүл мэндийн яамны салбарын хяналтын газрын баталсан 2023 оны "Төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай" удирдамжийн хүрээнд Баянзүрх, Улаан-Уул, Рэнчинлхүмбэ, Цагааннуур сумдын Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын сургууль болон хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагаанд эрүүл ахуй,халдвар хамгааллын хяналтын чиглэлээр төлөвлөгөөт хяналт шалгалтыг зохион байгуулж ажиллаа. Мөн дээрх сумдын эрүүл мэндийн байгууллагуудад дэмжлэгт хяналт хийж нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээнд зөвлөн туслах ажлыг зохион байгуулж ажиллаа.

Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлэг “Ерөнхий мэргэшил судлал” үндсэн мэргэшлийн сургалтыг орон нутагтаа шинээр зохион байгуулах бэлтгэл ханган ажиллаж эхэллээ.

Жайка олон улсын байгууллагын санхүүгийн дэмжлэгтэйгээр Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн хөгжлийн төвтэй хамтран Аймгийн Нэгдсэн эмнэлгээс эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтыг “Эмнэл зүйн сургагч багш” бэлтгэх сургалтыг орон нутагтаа зохион байгууллаа. Уг сургалтад Хөвсгөл аймгийн Эрүүл мэндийн газар, Нэгдсэн

эмнэлэг, сумын Эрүүл мэндийн төв, Орхон-Уул аймгийн БОЭТ болон нийт 24 эмч мэргэжилтэн бэлтгэгдсэн байна. Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлэг нь аймгийн малчдын зөвлөгөөнд оролцсон 200 гаруй малчдад дотор, мэдрэл, уламжлалт болон сүрьеэ өвчнийг илрүүлэх үзлэг, хэвлийн хэт авиан оношилгоо, зүрхний цахилгаан бичлэг, цээжний рентген зураг зэрэг үзлэг шинжилгээнд хамрууллаа.

Үүнд: Хэвлийн ЭХО 153, зүрхний цахилгаан бичлэг 139, умайн хүзүүний эсийн шинжилгээ 27 эмэгтэйд, дотрын эмчид 148, мэдрэлийн эмчийн үзлэг 70, уламжлалт 113, сүрьеэгийн илрүүлэг 142, нийт давхардсан тоогоор 790 гаруй эрүүл мэндийн үзлэг зохион байгууллаа.

Тус үзлэгээр бөөрний хоргүй хавдар шинээр 3 тохиолдол оношлогдож бөөрний эдийн өөрчлөлт 1, элэгний хатуурал 1, элэгний уйланхайцацарт өөрчлөлт 3, цөсний замын (чулуу, уйланхайцарт өөрчлөлт) эмгэг 2, өндгөвчний уйланхай 2, түрүү булчирхайн шохойжилт 8, зүрх, судасны эмгэг өөрчлөлт 8 тохиолдол онош батлагдаж нарийн мэргэжлийн эмчийн хяналтад эмчилгээ үйлчилгээг эхлүүлсэн. Малчин иргэдийн дунд хоол боловсруулах болон бөөр шээсний замын эмгэг зонхилон тохиолдож байна.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ХАЛАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Нийгмийн халамжийн ehalamj.mn системээр 2023 оны 5 сард 67664 иргэнд 6.6 тэрбум төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж олгосон.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн салбар комисс 2 удаагийн хурлаар 38 хүүхэд орсноос 13 хүүхдийг асаргаанд оруулсан. Хугацаатай байнгын асаргаанд байдаг 19 хүүхдийн асаргааг сунгасан. Мөн 1 хүүхдийн өргөдлийг буцааж, 1 хүүхдийн оношийг тодруулах шийдвэр гаргасан.

Шинэчилсэн аргачлалын дагуу өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгаа 2023 оны 5 сарын 29-ний өдрөөс эхлэн явагдаж байна. Аймгийн хэмжээнд 1308 өрхийг хамруулахаар ажиллаж байна. 2023 оны 6 сарын 5-ны өдрийн байдлаар 70 хувьтай явагдаж байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан нээлттэй хаалганы өдрийн хүрээнд Нийгмийн халамжийн ehalamj.mn-ийг иргэдэд сурталчлан таниулах, хүүхдийн мөнгөний талаарх мэдээлэл, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжийн талаарх өргөдлийг хүлээн авч ажилласан нийт 150 иргэд үйлчилгээг үзүүлсэн.

Ажилд зуучлах үйлчилгээнд 51 иргэнийг хамруулж, 312 иргэний идэвхтэй ажил хайгчаар бүртгэсэн байна. 443 шинэ ажлын байр бий болсон бөгөөд үүнээс байнгын ажлын байранд 69, улирлын ажлын байранд 158, түр ажлын байранд 218 иргэн ажилд орсон байна.

Эрүүл аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага” болзолт уралдааны гарааны үеийн үнэлгээг зохион байгуулсан. “Нээлттэй- Хөвсгөл” арга хэмжээний хүрээнд “Их, дээд сургууль төгсөгчдийг хөдөлмөрт бэлтгэх, ажлын байранд зуучлах” арга хэмжээг Улаанбаатар хотод зохион байгуулсан.

Тус арга хэмжээнд 300 оюутан төгсөгчдийг хамруулан хөдөлмөрт бэлтгэх, ажилд зуучлах, ажлын байрны мэдээлэлтэй танилцуулж холбогдох гарын авлага, зөвлөгөө мэдээллээр ханган ажиллалаа. Арга хэмжээнд нийгмийн гурван талт түншлэлийн өнөөгийн байдал, цаашид баримталж буй бодлого, аймаг орон нутгаас хөдөлмөрийн зах зээл дэх ажиллах хүчний оролцооны түвшин нэмэгдүүлэх талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээллийг өгснөөс гадна нийт 182 аж ахуйн нэгж, ажил олгогч 865 нээлттэй ажлын байрны мэдээллийг ирүүлж үзэсгэлэнд цахимаар болон танхимаар оролцлоо.

Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтнээр ахлуулсан ажлын хэсэг Мөрөн сумаас Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүгийн дэмжлэгт 2014-2022 онд хамрагдсан 391 өрхөд зочилж төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн ажилласан.

Боловсруулах үйлдвэрүүдэд төлөвлөгөөт хяналт шалгалт хийх удирдамжийн хүрээнд “Мөрөн бетон” ХХК, уул уурхай болон газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн хадгалалт, түгээлт, ашиглалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа “Мон-Ажнай” ХХК-нд хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтаар төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн.

Үйлдвэрийн осол, хурц хордлогоос урьдчилан сэргийлэх тухай албан даалгавар, боловсруулах үйлдвэр, уул уурхай, барилгын салбарт “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-ын хэрэгжилтэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийгдэж байна.

Хөдөлмөрийн эрхийн маргаантай холбоотой 1 иргэнээс өргөдөл ирснийг шалгаж, холбогдох шийдвэрийг гарган тухайн иргэнд хүргүүлсэн.

БИЕИЙН ТАМИР, СПОРТ, СОЁЛ УРЛАГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Соёл урлагийн газрын санаачилгаар зохиолч Ц.Гончигын “Зүүд урлаач хугашхан” хүүхдийн жүжгийг хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “50-100 event hall”-д тоглолоо.

Хөвсгөл аймгийн Хөгжимт драмын театрын уран бүтээлчид МУГЖ Р.Лхамжавын “Урлагийн тайзнаа 50 жил”-“Дэлтэй цэнхэр” тоглолтонд бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцлоо.

Гэрээр ном олгох танхимд ЕБС-ын төгсөх ангийн сурагчдад ЭЕШ-д зориулсан үзэсгэлэн гаргаж бүртгэн мэдээлэх ном зүйн жагсаалт гаргаж уншигчдад сурталчиллаа.

Мөн Монгол Улсын Төрийн шагналт, Ардын уран зохиолч, яруу найрагч Дэндэвийн Пүрэвдоржийн мэндэлсний 90 насны ойд зориулсан үзэсгэлэн гарлаа.

“Олон Улсын Музейн өдөр”- ийг (International Museum Day) өдөрт зориулж 25 номоор номын үзэсгэлэн гаргав.

“Үндэсний бичиг соёл, номын өдрүүд” - 2023 Номын баярын хүрээнд МУГБ, аймгийн Угийн бичгийн сургагч багш П. Лхагвасүрэнг урьж Титэм ЕБС-ийн Ц. Цэвээнсүрэн багштай 10б ангийг ханд “Угийн бичиг” хөтлөх анхан шатны сургалтыг амжилттай зохион байгууллаа.

Монгол бичгийн “Тэргүүний хурдан уншигч” шалгаруулах тэмцээн зохион байгуулав. Тус тэмцээнд нийт 17 сургуулийн ахлах болон дунд ангиас нийт 70 гаруй хүүхэд оролцов.

Нийтийн биеийн тамирын чиглэлээр 4 арга хэмжээнд 1218 хүн хамрагдаж, аймгийн аварга шалгаруулах арга хэмжээнд 60 хамрагдсан. Улсын аварга шалгаруулах 3 төрлийн тэмцээнд нийт 20 тамирчин оролцож, Алт-3, Мөнгө- 2, Хүрэл-3 хүрэл, Олон улсын 2 төрлийн тэмцээнд 47 тамирчин хамрагдаж , Алт-3, Мөнгө-2, Хүрэл-4 тус тус хүртсэн байна.

Фитнесс клубуудын судалгааг гаргаж чиглэл чиглэлээр нь болгох бодлого барьж, ажиллах талаар Биеийн тамир спортын Улсын хороо мэргэжилтэнгүүд, сургалт хийж мэдээлэл өглөө. Сургалтад Биеийн тамир спортын газрын арга зүйчид, фитнес төвийн багш, дасгалжуулагч нийт 6 хүн хамрагдлаа.

“Цаг гаргая” аяны хүрээнд гүйлтийн 7 хоногийг өдрүүдийг зохион байгуулж гүйлтэнд нийт 14 байгууллагын 568 ажилтан албан хаагчид 100 гаруй иргэд оролцлоо. Энэ үеэр Биеийн тамир

спортын арга зүйчид иргэдэд гүйлтийн аппликейшн суулгаж өгч зөвлөгөө өгөн гарын авлага материал тархаан ажиллаа.

Аймгийн аварга шалгаруулах “Уран хөдөлгөөнт гимнастик”-ийн тэмцээн 2023.05.27 нд амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд төвийн 10, хөдөө сумдын 6 цэцэрлэгийн нийт 16 цэцэрлэгийн 300 гаруй цэцэрлэгийн хүүхдүүд амжилттай оролцлоо.

Тэмцээнийг БШУГ, ГБХЗХГ, БТСГ “Мөрөнжин” хүүхдийн 11-р цэцэрлэг хамтран зохион байгууллаа. Сургуулийн өмнөх боловсролын Уран хөдөлгөөнт гимнастикийн тэмцээний шагналыг УИХ-ын дэд дарга, УИХ-ын гишүүн Лхагвын Мөнхбаатарын ажлын алба, “Тэс-Гүн” хязгаарлагдмал хувьцаат компанийн захирал Д.Нарантуяа, Аяны жолоо, Тойхийт хайрхан, Хөвсгөл хүнс, Элбэг мөрөн, Сүлд-бумбат, Оюу-Өргөө, Эх нутгийн дэвшилт төрийн бус байгууллагууд ивээн тэтгэж шагналыг гарган оролцлоо.

Гимнастикийн тэмцээнийг Аэробик гимнастикийн ОУХМ, Монгол Улсын итгэжлэгдсэн шүүгч Э.Мөнхнасан, ОУ-ын дасгалжуулагч, ОУ-ын шүүгч, Аэробик гимнастикийн Олимпын циклд шүүх эрх авсан, СДМ Ж.Нямжаргал, ДМЦС-ийн биеийн тамирын багш Аэробик гимнастикийн СДМ Н.Мандахцэцэг, Аэробик гимнастикийн Монгол Улсын Итгэмжлэгдсэн шүүгч Б.Ганчимэг, Аэробик гимнастикийн СМ Б.Оргилболд нар шүүн явууллаа.

Аймгийн аварга шалгаруулах “Аэробик гимнастик”-ийн өсвөр үеийн тэмцээнийг А,Б ангилалаар зохион байгуулж 10 байгууллагын 250 гаруй хүүхдүүд амжилттай оролцлоо.

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын харьяат Хил хамгаалах ерөнхий газрын Хилчин спорт хороо Хилийн цэргийн 0257-р ангийн бөх МУ-ын начин Б.Баянмөнхийн нэрэмжит Үндэсний бөхийн насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулагдаж шилдгүүдээ тодрууллаа.

Хөвсгөл аймгийн 17 сум байгууллагын 60 гаруй бөхчүүд 4 хэсэгт хуваагдан барилдаж шилдэг 16 бөхөө тодрууллаа.

Аэробик гимнастикийн Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнд 16 байгууллагын 100 гаруй тамирчид оролцлоо. Хөвсгөл аймгаас 7 тамирчин оролцож 2 алт, 1 мөнгө, 1 хүрэл медаль хүртлээ.

Дархан хотод зохион байгуулсан “Дархан Open” бадминтоны нээлттэй тэмцээн зохион байгуулагдаж 6 аймаг дүүргийн 120 гаруй тамирчид 4 насны ангилалд өрсөлдлөө.

Энэ тэмцээнд Хөвсгөл аймгаас 5 тамирчин оролцож багийн дүнгээр 3-р байр, Монголын бадминтоны холбооноос зохион байгуулсан онлайн хурал болж сонирхогчдын УАШ-лах тэмцээн, Монгол улсад болох ОУ-н тэмцээн, Хүүхдийн спортын их наадам, Ханжоуд болох азийн тоглолт, Банкок Тажикстанд болох ОУ-ын тэмцээний талаар ярилцаж мэдээлэл өглөө

МУГТ Доржпаламын Нармандахын нэрэмжит өсвөр үеийн олон хотын нээлттэй тэмцээн Орхон аймаг эрдэнэт хот Хангарьд Паласт зохион байгуулагдлаа. Хөвсгөл аймгийн 45 тамирчин 2 дасгалжуулагч оролцож эмэгтэй багийн тэмцээнд 3-р байр эзэллээ.

Таван орны Олон улсын нээлттэй тэмцээн 5 нас, 30 жингийн ангиллаар 200 гаруй тамирчид өрсөлдөж Хөвсгөл аймгаас 3-н тамирчин оролцож 55-60 насны ангилалд О.Баатархүү Алтан медаль, 40-45 насны ангилалд Д.Пүрэвдорж Хүрэл медаль, 40-45 насны ангиллын 80 кг жинд Г.Гансүх шагналт 5-р байр тус, тус эзэлсэн амжилттай оролцлоо. 2023 оны 4-р сарын 1-6 нд болсон өсвөрийн шатарчдын улсын аварга шалгаруулах тэмцээнд 1000 хүүхэд оролцсон. Тус

тэмцээнд Хөвсгөл аймгаас 23 хүүхэд тоглноос 1 алт 1 мөнгөн медаль хүртэж багийн дүнгээр анх удаа УАШТ-ийн аварга болж алтан цом хүртлээ.

Уулын дугуйн улсын аварга шалгаруулах тэмцээн Төв аймгийн зуун мод хотод болж өнгөрлөө. Хөвсгөл аймгийн баг тамирчид оролцож 14 байгууллагын 170 гаруй тамирчдаас 9 тамирчин 1 Мөнгө, 3 Хүрэл медаль хүртэж багийн дүнгээр 4-р байр эзэллээ.

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД, ЖЕНДЭРИЙН БОДЛОГО ЧИГЛЭЛЭЭР:

Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас 2023 оны 5 дугаар сард 12 үйл ажиллагаа, үйлчилгээ, сургалт, нөлөөллийн ажилд 40 хүүхэд, 3646 насанд хүрэгч, 30 гэр бүл, 421 залуучууд хамрагдсан байна.

Байгууллагын фейсбүүк хуудсаар дамжуулан 14 зөвлөмж, 23 мэдээ, 2 ажлын байрны зар, 2 санал асуулга, 5 мэдээлэл, 1 лайв, 4 танилцуулгыг иргэд олон нийтэд хүргэж 508 хандалт авсан байна.

Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудыг хөгжлийн газрын дэргэдэх “Нэг цэгийн үйлчилгээний төв” нь гэр бүлийн хүчирхийлэл болон бэлгийн хүчирхийллийн хохирогчийг харьяалал харгалзахгүй хүлээн авч 7 төрлийн үйлчилгээг үзүүлэн, 2023 оны 05 дугаар сарын байдлаар нийт 37 иргэн үйлчлүүлсэн байна.

Үүнээс өдрөөр насанд хүрэгч 23 иргэн хамрагдсанаас 16 эмэгтэй, 7 эрэгтэй, байсан бол 14 хүүхдээс 3 эрэгтэй, 11 эмэгтэй, 14 иргэн түр хамгаалан байрлуулах үйлчилгээг үзүүлсэн.

Ахуйн хүрээний архидалт нэмэгдэж, өрхийн төвшинд стресс нэмэгдсэн нь бага насны хүүхдүүд эцэг, эхийн зүгээс сэтгэл санааны хүчирхийлэлд өртөх, мөн анхаарлын гадна хараа хяналтгүй орхигдох, үл хайхрах хүчирхийлэлд өртөх явдал ихсэж байна.

Жил бүрийн 04 дүгээр сарын 30-ны өдөр “Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг өдөр” тохиодог. Энэ жилийн хувьд үндэсний хэмжээнд “Гэрэлт ирээдүйд Гар бүү хүр” уриа дор тэмдэглэн сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулав.

Мөн залуу гэр бүлд чиглэсэн гэр бүлийн боловсрол олгох, “Гэр бүлийн харилцаа”, хүүхэд хүмүүжлийн эерэг аргын талаарх “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга түүнд суралцах нь” сургалт, нөлөөллийн ажлыг Мөрөн сумын 9 төрийн байгууллагын 500 ажилтан, албан хаагчдад зохион байгуулсан.

Олон улсын гэр бүлийн өдрийг “Хүн ам зүйн чиг хандлага ба гэр бүл” сэдвийн хүрээнд Гэр бүлийн волейболын тэмцээн, “Хайрын болзоо” нөлөөллийн арга хэмжээ, залуу хосуудад гэрлэлтийн гэрчилгээ олгох өрөөний нээлт болон санамж бичиг байгуулах үйл ажиллагаа, цахим орчинд нөлөөллийн постер бэлтгэж, түгээх, “Шинэ Мөрөн- Шинэ хандлага” сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах, гэрлэлтийн андгай өргөх, ёслол хүндэтгэлийн арга хэмжээг тус тус зохион байгууллаа.

Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн даргаар ахлуулсан Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын ээлжит хурал зохион байгуулагдаж хурлаар 25 хүүхдийг хэлэлцэн шийдвэрлэж, 2 хүүхэд түтгэлзсэн.

2023 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн байдлаар Хүүхдийн тусламжийн 108 утсанд 149 дуудлага бүртгэгдсэн. Дуудлага өмнөх оны мөн үеэс 31,8%-аар өссөн. 68 дуудлагыг бүрэн шийдвэрлэсэн, 81 дуудлага шийдвэрлэх шатанд байна.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас 14 хоног тутамд Хүүхдийн тусламжийн 108 утасны кейс хэлэлцүүлэг зохион байгуулагдаж байна. Тус хэлэлцүүлэгт Хөвсгөл аймгийн дуудлагын шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг танилцуулж, зөвлөмж авч ажиллалаа. Мөн 24 сумын нийгмийн бодлогын мэргэжилтнүүдэд цахимаар мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, дуудлага мэдээлэлд хяналт тавьж, шийдвэрлэсэн кейсийг программд бүрэн хааж ажилласан.

Аймгийн Засаг даргаар ахлуулсан Хүүхдийн төлөө зөвлөлийн ээлжит бус хуралдаан зохион байгуулагдаж хуралдаанаар зөвлөлийн дүрмийг хэлэлцэн баталж, хүүхдийн “Уран дөш” зуслангийн өнөөгийн нөхцөл байдал, цаашид анхаарах асуудлын талаар ярилцав.

Хөвсгөл аймаг дахь Политехник коллежийн оюутан 65 суралцагч, Мөрөн сумын 3 сургуулийн 11-12-р ангийн нийт 60 сурагчдад “Сайн дурын ажлын онцлог, залуучуудын оролцоо” сэдвээр сургалт зохион байгуулав.

Тав. Мал аж ахуй, газар тариалангийн талаар:

“Хоймор нутгийн малчдын зөвлөлдөх уулзалт” амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Зөвлөлдөх уулзалтад аймгийн удирдлагууд Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрлэлийн яамны Генетик нөөцийн хэлтсийн дарга Ц.Мөнхнасан, “Эйл Би Эйч Технологи” ХХК гүйцэтгэх захирал О.Дашдулам, Тус компани зөвлөх багш, доктор Д.Бямба, “Эс эф си эс” органик баталгаажуулалтын компаний захирал Л.Тунгалаг, Мал амьтны бүртгэл мэдээллийн үндэсний холбооны гишүүн Ү.Дамдиндорж, Г.Алтанхуяг, Чинээлэг малчин хөтөлбөрийг санаачлагч Х.Эрдэнэбаатар, Хөдөө аж ахуйн биржийн арилжааны мэргэжилтэн С.Энхжин, “Лидер Хүнс” ХХК-ний технологич Ж.Сосорбарам, “Хөгжлийн шийдэл” Төрийн бус байгууллагын бизнесийн зөвлөх Ш.Даваагарав, Дэлхийн зөн олон улсын байгууллагын Орон нутаг хариуцсан мэргэжилтэн Ш.Дулмаахүү, Банк санхүүгийн байгууллагын төлөөлөл оролцож илтгэл мэдээлэл хүргэлээ.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2018 оны А/145 дугаар тушаалаар баталсан “Үржлийн малд хянан магадлагаа хийх, баталгаажуулах, үүлдэрлэг байдлыг тодорхойлох, хяналт тавих журам”-ын дагуу Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ, Цагааннуур сумдад үржүүлж буй нутгийн шилмэл үхэрт ашиг шимийн тодорхойлолтыг үндэслэн намрын улирал (2022 оны 11 дүгээр сард)-д үржил селекцийн ажлын үр дүнтэй газар дээр нь танилцаж, “Хогорго үхэр”-ийн тодорхойлолтын материал үнэн зөв эсэхэд журмын дагуу хянан магадлагаа хийж гүйцэтгэлээ.

Цагаан-Уул сум нь аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс үлийн цагаан оготной тэмцэх ажилд 1тн бактерийн бэлдмэл авахаар 7,5 сая төгрөгийг зарцуулахаар хөрөнгийг шийдвэрлүүлж Сумын Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А/93 захирамжаар ажлын хэсэг байгуулан бэлчээрийн үлийн цагаан оготной 400га талбайд микробиологийн аргаар тэмцэж орон нутагтаа зохион байгуулж ажиллалаа.

Тус арга хэмжээнд Сумын Засаг даргын Тамгын газрын дарга, Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн, бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг хэсэгт ажлыг стандартын дагуу шуурхай, үр дүнтэй зохион байгуулах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө 51 иргэдэд хүргэн ажилласан. Цаашид жил бүр экологи, биологийн зохистой хугацаанд нь болох хавар, намрын арга хэмжээгээр зохион байгуулж ажлыг тасралтгүй явуулах багийн Засаг дарга болон малчдын үүрэг оролцоог илүү сайн хангаж ажиллах саналыг хүргүүлсэн.

2023 оны 05 дугаар 06-нд “Хүнсний хангамжийг нэмэгдүүлэхэд тариаланчдын оролцоо-2023” зөвлөгөөнийг 250 гаруй газар тариалан эрхлэгчдийг хамруулан зохион байгуулсан.

Хүнсний хангамжийг нэмэгдүүлж, аюулгүй байдлыг хангах жилийн хүрээнд хаврын тариалалтад шаардлагатай

- Хүнсний ногооны үр үрсэлгээ
- Хүлэмжийн нарийн ногооны болон мандлын цэцгийн үрслэг
- Хонины ноосон болон бусад төрлийн бордоо
- Төрөл бүрийн модны үр суулгац
- Зуны нийллэг хальсан хүлэмж болон тоног төхөөрөмжүүдээр нээлттэй үзэсгэлэн худалдааг Чингүнжавын талбайд зохион байгуулав.

Хөвсгөл аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсаны дагуу мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах талаар малчдын анхаарах асуудлаар “Эрх чөлөө” сонинд мэдээлэл нийтлүүлэв. MNS ISO/IEC 17125:2018 Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавих ерөнхий шаардлага хангасан итгэмжлэлд орох өргөдлийн маягт, хүсэлт, чанарын гарын авлага, холбогдох журмыг УМЭАЦТЛ-ын ерөнхий эмчээр баталгаажуулж, Үндэсний итгэмжлэлийн төвд хүргүүлэв.

Засгийн газрын 10 дугаар хуралдааны шийдвэр, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2023 оны 1 сарын 31-ны өдрийн А/19 тушаалаар батлагдсан "Дархлаажуулалтын төлөвлөгөө", аймгийн Засаг даргын 2023 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн А/156 дугаар захирамжийг хэрэгжилтийг ханган шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулан ажиллаж байна.

Дархлаажуулалтын явц 2023 оны 06 дугаар сарын 05-ны байдлаар 522,865 мянган толгой мал хамрагдаж 83.2 хувийн гүйцэтгэлтэй хийгдэж байна

Аймгийн хэмжээнд хийгдэж байгаа мал, амьтны сэг зэм устгал ариутгалын ажлыг эрчимжүүлэн ажиллаж байна. 2023 оны 06 дугаар сарын 05-ний байдлаар зүй бусын хорогдол 104,547 үүнээс сэг зэмийн устгалаар 54629 толгой буюу 52.2 хувийг нь устгаж, 422,584 мкв талбайд ариутгал халдваргүйтгэл хийсэн байна.

Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль, Засгийн газрын 2018 оны 266 дугаар тогтоол, МЭЭГ-ын даргын 2019 оны А/04 тушаал “Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх зааврыг хэрэгжүүлэн, аймаг сумын засаг даргын захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллаж, “Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай” аймгийн Засаг даргын А/316 дугаар захирамжийг гаргуулж дархлаажуулалтын ажлыг 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрөөс эхлүүлж байна.

Сумдад Голомтын бүс, сэжигтэй бүсүүдэд хяналтын цэгийг шинээр байгуулах, ажлыг эрчимжүүлэх, малын шилжилт хөдөлгөөнд тавих хяналтын ажлыг сайжруулах зөвлөмж өгөв.

Сумдад хэмжээнд багийн малын эмч, мал эмнэлгийн нэгжийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлэх зөвлөмж өгөв.

БАЙГАЛЬ ОРЧНЫ ЧИГЛЭЛЭЭР:

Бүх нийтээр мод тарих үндэсний өдрийг 5 сарын 06-наас 05 сарын 30-ны өдөр хүртэл мод тарилтын ажлыг үргэлжлүүлж байна. “Нэг хүүхэд нэг мод” уриалга гарган Мөрөн сумын ЕБСургуулиудад тус бүр 1000 улиас ны мөчир хандивласан. Уранмандал уулын ард байгуулсан ойн зурваст нөхөн тарилт хийж 400 ширхэг улиас тарив.

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

Монгол Солонгосын засгийн газраас хэрэгжүүлж буй “Ногоон хэрэм-3” төслийн хүрээнд Нисэх багт хийх ойн зурвасын ажил явагдаж байна.

Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд шилдэг БОТХБТасаг шалгаруулан түймрийн багаж эрлон цуравдагчаар урамшуулсан. БОАЖЯамны ойн газрын судалгааны багт ажиллаж ойн хөнөөлт шавжийн судалгааг хийж 31000 га талбайд тэмцлийн ажил хийгдэхээр боллоо.

"Хүн бүр байгаль хамгаалагч" аяны хүрээнд Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас баталсан төлөвлөгөөт хяналт шалгалтын удирдамж, Мөрөн сумын Засаг дарга Байгаль орчин аялал жуулчлалын газрын даргын баталсан удирдамжийн хүрээнд Мөрөн суманд үйл ажиллагаа явуулж буй загас, загас бүтээгдэхүүн үйлдвэрлэж худалдан борлуулдаг иргэн, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж зөвлөмж чиглэл өгч ажиллалаа.

Бүрэнтогтох сумын Дулааны төвийн хаягдал утаанд хэмжилт хийв. Бүрэнтогтох сумын Туяа багийн нутагт хамрагдаж буй Дэлгэрмөрөн голын сав газарт эвдэрсэн газруудад нөхөн сэргээлт хийгдсэн ажлын талаар болон цаашид хийгдэх нөхөн сэргээлтийн ажлыг нөхөн сэргээлт хийх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээр хийлгэх, нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийж байгаад хяналт тавих, гэрээ хийж байгаа бол гэрээний биелэлтийг гаргаж, хүлээн авах акт үйлдэх талаар санал солилцлоо.

Цэцэрлэг сумын Могойн голын уурхайгаас нүүрс тээвэрлэсэн аж ахуйн нэгжид үүсгэсэн зөрчлийн хэргийг үргэлжлүүлэн шалгаж, нэмэлт материал бүрдүүлэх ажлыг гүйцэтгэж байна. Нэмэн ХХК-ний 2 ШТСтанцад шалгалт хийж, албан шаардлага хүргүүлээ. Нэмэн ХХК-ний оффисын барилгын усан халаалтын зууханд утаа хэмжих хоолой гагнуулах ажлыг хийлгэлээ.

Газрын төлбөр, татварын системийн хүрээнд: 2023 оны 06 сарын 01-ны байдлаар Газрын кадастрын систем дээр газрын татвар, төлбөрийн ногдуулалт аймгийн хэмжээнд нийт гэрээний тоо 23994, ногдуулалт үүссэн гэрээний тоо 20486, нэхэмжлэх үүссэн гэрээний тоо 18765, төлөлт бүртгэгдсэн гэрээний тоо 4596, ноогдуулсан нийт төлбөр 674702.0 сая.төгрөг, нэхэмжилсэн төлбөр 561032.5 сая.төгрөг, төлсөн төлбөр нь 195379,9 сая .төг төлсөн байна.Орлогын биелэлт 45,8 хувьтай байна.

Газрын төлбөр, татварын системийг Татварын удирдлагын нэгдсэн системд улсын тэмдэгтийн хураамжийн ногдуулалтыг үүсгэж, Татварын удирдлагын нэгдсэн системд 146 тэмдэгтийн хураамжийг илгээж, нэхэмжлэх болон төлбөрийн даалгаврын дагуу төлөгдсөн төлбөрийг шалгах энэхүү системийг өдөр тутмын үйл ажиллагаандаа тогтмол ашиглаж хэрэгжүүлж ажиллаж байна. Газрын үнэлгээний системээр газрын эдийн засгийн үнэлгээний хүрээнд:

“Хаягжуулалтын тухай хууль”, “Засгийн газрын 2019 оны 235 дугаар тогтоол”-оор "Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам"-ыг шинэчлэн баталсан бөгөөд уг журмын дагуу Мөрөн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн хуралдааны 2016 оны м04 дүгээр сарын 22-ны өдрийн №26 дугаар тогтоолоор Мөрөн сумын 14 багийн гудамжны нэршил шинэчлэн баталсан.

Мөн “Хөвсгөл аймгийн хаягийн атласын ном”-ын дагуу Мөрөн сумын 442 гудамж, 1900 замыг зураглан түүнээсээ 10924 нэгж талбарт газрын кадастрын хаягийн системээр дамжуулан хаяг олгосон ба энэ оны хагас жилийн байдлаар шинээр орон сууцны 3 барилга байгууламжид журмын дагуу шинэчилсэн хаяг өгөөд байна.

ХЯНАСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА Х.ЦЭНД-АЮУШ

НЭГТГЭСЭН:

ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Б.БАЯРМАА